

А.Цэрэндолгор

(“Хийморь Алтай групп” Мал эмнэлгийн
нэгжийн эмч)

В.Гэрэлтуяа

(Хог хаягдлын олон нийтийн байцаагч)

Г.Мөнхжаргал

(Хогны машины жолооч)

М.Эрдэнэбаатар

(Хогны машины ачигч)

4. Ажлын хэсгийн гишүүдийг мэргэжилт, арга зүй, удирдлага, шаардагдах ариутгалын бодисоор хангах, ажлын явцын гүйцэтгэлд дотоодын хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулан, ажил үйлчилгээний чанар, заавар журам, технологийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлэг тасгийн улсын байцаагч /Ш.Буяннэмэх/-д, тайланг нэгтгэн сумын Засаг даргад танилцуулахыг Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн /Д.Эрдэнэтулга/-д, Ариун цэврийн ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажил үйлчилгээг чанарын өндөр түвшинд, технологийн дагуу хийж гүйцэтгэхийг “Хийморь Алтай групп” Мал эмнэлгийн нэгжийн эмч /А.Цэрэндолгор/ нарт тус тус үүрэг болгосугай.


5. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Отгонжаргал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ

Сумын Засаг даргын 2021 оны 03-р сарын 04-ны өдрийн 110 дугаар захирамжийн 1.1-р хавсралт



Мал эмнэлгийн ариун цэвэр,
сэг зэм устгах ажлын удирдамж

Зорилго: Сумын нутаг дэвсгэрт байгаа мал, амьтны сэг зэм, түүгээр бохирлогдсон газар, хашаа хороо саравчыг мал эмнэлгийн халдваргүйжүүлэлтэнд хамруулж, мал амьтны халдварт, паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, байгаль орчныг цэвэр цэмцгэр байлгахад оршино.

Сумын түвшинд хийгдэх ажил:

- Мал эмнэлгийн ариун цэвэр, халдваргүйжүүлэлтийн ажлыг хавар 2021 оны 03-р сарын 04-ны өдрөөс эхлэн 3 хоногийн хугацаанд, намар 2021 оны 10 дугаар сарын 01-ны өдрөөс 30-ны өдөр хүртэл 30 хоногийн хугацаанд явуулах
- Сумын МЭТасаг ажлыг ахлаж багийн түвшинд мал эмнэлгийн ариун цэвэр, халдваргүйтгэлийн ажлыг төлөвлөж, батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх, ариутгал халдваргүйтгэл хийх цэг, талбай, байрны солбицлолыг ArcGIS-ийн зураглал гаргаж нэгтгэх
- МЭН-ийн малын эмч мал эмнэлгийн ариун цэвэр, ариутгал халдваргүйтгэлийн ажлыг технологийн дагуу, төлөвлөсөн хугацаанд хийж гүйцэтгэх
- Малчин, мал бүхий иргэд өөрийн орчинд байгаа сэг зэмээ устгал хийх цэгт хүргэж өгөх
- Багийн Засаг дарга нар ажлын мэдээллийг малчин, мал бүхий иргэдэд мэдээллийг хүргэх

Мал эмнэлгийн байгууллага, аж ахуйн нэгжийн хийх ажил:

- Сэг зэм булсан нүхнүүдэд стандартын дагуу ариутгал хийх
- Малчин, мал бүхий иргэдийн хашаа хороо, бууцыг бүрэн хамруулна:
Үүнд: мал, амьтны хашаа хороо, саравч, морины уяа, шон, хэвтэр бууц, төлийн пүнз, өвс тэжээлийн хашаа саравч, тоног хэрэгсэл, тэжээлийн онгоц, дэвсгэр хөрзөн, худаг, уст цэг, саравч, унага, тугалын зэл, нохойны уяа, малын нэмнээ, малын хүүр, сэг зэм зэрэг хамрагдана.
- Сумын төвийн малын гаралтай түүхий эд, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээ явуулдаг нэгжүүд, хүнсний дэлгүүр, зах, зоорь, агуулах, хаягдлын нүх, бохирын цооног, тээвэрлэх зөөвөрлөх хэрэгсэл, ажиллагсдын ажлын хувцас зэргийг ариутгах
- Гахай, шувуутай иргэдийг мал эмнэлгийн халдваргүйжүүлэлтэнд бүрэн хамруулж, мал амьтны халдварт, паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх

Малчид мал бүхий иргэд, аж ахуйн нэгжийн түвшинд:

- Мэргэжлийн байгууллагын заавар зөвлөмжийн дагуу ариун цэвэр халдваргүйтгэлийн ажилд идэвхитэй оролцох
- Малын хашаа хороог цэвэрлэх, бохирдол ихтэй хэсгийг тусгаарлан шатаах ажлыг гүйцэтгэж халдваргүйтгэл хийхэд бэлэн болгох
- Өвөлжөө, хаваржааны ойр орчимд байгаа мал, амьтны сэг зэмийг цуглуулан сэг зэмийн устгал хийж байгаа газар хүргэж өгөх, булаг шандны эхийг цэвэрлэх
- Малын гаралтай түүхий эд, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээ явуулдаг нэгж, хүнсний дэлгүүрүүд халдваргүйжүүлэлтийн өмнө урьдчилсан цэвэрлэгээг халуун усаар сайтар хийсэн байх.

Удирдамж боловсруулсан:

МЭТ-ийн улсын байцаагч *Ш. Буян* /Ш.Буяннэмэх/


БАТЛАВ

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Д.ОТГОНЖАРГАЛ

..... оны-р сарын –ны өдөр

Сэг зэм устгах газрын зураглал



2021.03.05 - 03.06–ны өдөр төв хогийн цэг, Урсахын ухаа, шоовойн говь, төв хогийн цэг, зүйтийн тал, хар толгой, тогоо булаг, Хар ам, хогийн цэг, сэвхүүлийн говь, Хүрэн дух, хаялага, 21-р зөрлөг, хогийн цэг, 22-р зөрлөг, хогийн цэг гэсэн маршрутаар сэг зэм устгалын ажлыг 2 өдөр зохион байгуулан ажиллана.

Нийт: 639 км / 2 машин явна /